

**“ТЭЭВЭР АЧЛАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 07-р сарын 02

№ 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирцийн тухай
болон хурал хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, компанийн дүрмийн 7.4 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд 53'517 ширхэг нэгж хувьцаа эзэмшигч биеэр оролцож байгаа нь нийт саналын эрхтэй хувьцааны 90,47 % болж байна.

Хоёр. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, компанийн дүрмийн 7.4 дахь хэсгийг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 90,47 хувийг эзэмшигч хуралд оролцож байгааг үндэслэн компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



/Д.БААТАРНЯМ/

**“ТЭЭВЭР АЧЛАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 07-р сарын 02

№ 01

Улаанбаатар хот

Компанийн үйл ажиллагааны чиглэлд зарим өөрчлөлт орсонтой холбогдуулан гаргасан шийдвэрийг үндэслэн тогтоох нь:

Нэг. Компанийн дүрмийн “Компанийн эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэл” гэсэн 3 дугаар зүйлд дараахь өөрчлөлтийг оруулсугай. Үүнд

Компанийн дүрмийн 3.3.1-д

- Худалдааны зуучлал
- Агуулахын үйл ажиллагаа эрхлэх гэж

Мөн дүрмийн 3.4.1-д

- Хүнсний бөөний худалдаа
3.4.2-д
- Аялал жуулчлал гэж өөрчлөн оруулсугай

Хоёр. Компанийн дүрмийн дээрхи 3-р зүйлд урьд нь байсан

- Хот хоорондын нийтийн зорчигч, шуудан тээврийн үйлчилгээ
- Авто машины засвар үйлчилгээ
- Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ
- Жуулчин тээвэр гэсэн үйл ажиллагааны чиглэлийг компанийн дүрмээс тус тус хассугай.

Гурав. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр гаргуулж авахыг Санхүүгийн зохицуулах хороогоор уламжлан УБЕГ-т хүсэлт болгосугай.

Дөрөв. Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр авахтай холбогдуулан /компанийн хувьцаа эзэмшигчдийн судалгаа болон хурлын материалыг/ холбогдох материалыг хавсарган бүрдүүлсугай.

Тав. Компанийн улсын бүртгэлийн шинэ гэрчилгээ болон өөрчлөлт хийгдсэн компанийн дүрмийг баталгаажуулан авахыг компанийн гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА:



И.Д.БАЛГАРНЯМ